



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/494

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “Нүүдэлчин Монгол-2022” Соёлын биет бус өвийн их наадамд Төв аймгаас оролцох өвлөн уламжлагчдын бэлтгэл зохион байгуулалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 2,866,900 (хоёр сая найман зуун жаран зургаан мянга есөн зуу) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

ТӨРИЙН САН
МЭРГЭЖИЛТЭН 266

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 26-ний өдрийн
А/494 дугаар захирамжийн хавсралт



НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022 ИХ НААДАМД ОРОЛЦОХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Гарын бэлэг- (Могол ноос)	ш	15	36000	540,000
2	Гарын бэлэг- (Нутаг брэнд)	ш	20	44970	899,400
3	Хоол	ш	23	12000	277,500
4	Айраг, цагаан идээ	л	230	5000	1,150,000
	Нийт				2,866,900

ТӨСӨВ НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН: *А.Хажидмаа* А.ХАЖИДМАА

ТӨСӨВ ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Ч.ЦЭЦЭГСҮРЭН

